

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

1. Төслийн танилцуулга	3
2. Уулын ажлын технологийн дэс дараалал	5
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	6
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	11
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
8. Нэг сая модны төлөвлөгөө	20
9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	23
11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
13. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
16. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	34
17. “Багануур” ХК-ийн 2024 оны байгаль орчны ажлын төсөв	36
18. Хавсралт материал	37

ХАВСРАЛТУУД



1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар /МУ-001371, МУ-013631, МУ-013630, МУ-021484/
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас
 - a. Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл
 - b. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт
 - c. Хадгалагдаж буй химийн бодисын жагсаалт
 - d. БОННУ-ийн нэмэлт тодотголын тайлан
 - e. Байгаль орчны аудит
 - f. Ус ашиглалтын дүгнэлт
 - g. Уулын ажлын төлөвлөгөөний баталгаажсан нүүр
 - h. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний хавсралт маягтууд /1.1, 2.1, 6.2, 7, 10/
 - i. Хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагаа
 - j. Мета мэдээлэл
 - Тосгон
 - Хог хаягдлын цэгийн байршил
 - Аюултай хог хаягдлын агуулахын байршил
 - Химийн бодисын агуулахын байршил
 - Орчны хяналт шинжилгээний дээж авах
 - Усны дээж авах цэгийн байршил
 - Хөрсний дээж авах цэгийн байршил
 - Хяналтын цэгийн байршил
 - Агаарын хяналтын цэгийн байршил
 - Цацрагийн хяналтын цэгийн байршил
 - Тухайн жилд хуулах хөрс
 - Гадаад, дотоод овоолго
 - Техникийн нөхөн сэргээлтийн талбай
 - Мод тарих талбайн байршил
 - Гүний худгийн байршил
 - Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил
4. Барьцаа хөрөнгө байршуулсан баримт
5. Уурхайн дэвсгэр зураг

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Нүүрсний орд ашиглах

Төсөл хэрэгжүүлэгч: “Багануур” ХК, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг.

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, байршил: Багануурын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн хойш 130 км, Төв аймгийн Баяндэлгэр сумын төвөөс зүүн тийш 15 км зайтай, Тавансувайн талд, Хэрлэн голын савд оршдог. Мааньт ертөөтэй 80 км төмөр замаар холбогддог ба Улаанбаатараас Дорнодын чиглэлд тавигдсан асфальт бетон хучилттай авто зам дайран өнгөрдөг.



Уурхайн ашиглалтын өнөөгийн байдал:

“Багануур” ХК нь анх 1978 онд байгуулагдсан бөгөөд 1995 онд төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болж өөрчлөгдсөн. Багануурын нүүрсний уурхай нь 1978 оноос 2006 он хүртлэх хугацаанд жилд дунджаар 2.8-3.2 сая тонн хүрэн нүүрс олборлож, 32.0-34.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, Монгол улсын нүүрсний хэрэгцээний 68%, төвийн түлшний хэрэгцээний 78%-ийг хангадаг байв. 2015 оны 2-р сард 100 дахь сая тонн нүүрсээ олборлосон.

Уурхай одоогийн байдлаар тээвэртэй болон тээвэргүй гэсэн хосолсон системээр Уулын 1-р хэсэг ба Уулын 2-р хэсэг 2 хэсэгт ашиглалтыг явуулж байна. Уулын ажлын өрнөлт нүүрсний давхраасын уналын дагуу явагдах бөгөөд нүүрсний уналаа дагаж жил ирэх тусам 4-6м гүнзгийрч байдаг.

Уурхайг ашиглах төслийн гүн 300 метр бөгөөд өнөөдрийн байдлаар уурхайн гүн Уулын 1,2-р хэсэгт хамгийн их 125 метрт хүрээд байна.

Хүчин чадал, ашиглалтын хугацаа: Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая тонн бөгөөд хэрэглэгчдийн хэрэгцээнээс хамаарч 4.5 сая тонн нүүрс олборлож, 17 сая шоо метр хөрс хуулж байна.

Цаашид шинээр боловсруулагдсан ТЭЗҮ-ний дагуу Хойноос-урагш уулын ажлын ахилттай авто тээвэртэй ашиглалтын технологээр ажиллах ба нүүрсний олборлолт, борлуулалтыг 4-10 сая тн хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлэхээр

"Багануур" ХК-аас гаргасан прогноз төсөөлөл болон уурхайн төсөл зохиомжийн эцсийн хил хязгаар доторх 812 сая тн нүүрсний нөөц зэргийг үндэслэн, уурхайн ашиглалтын нийт хугацааг 58 жил гэж ТЭЗҮ-д тооцоолсон.

Ордын нөөц: 1974-1975 оны геологи хайгуулын ажлаар Багануурын нүүрсний ордын нийт нөөц А+В+С1+С2 зэрэглэлээр 599.82 сая.тн гэж тогтоогджээ. 2014 онд хийгдсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгээр нөөцийг нийт 812 сая.тн гэж тогтоогдсон нь өмнөх нөөцөөс 212.18 сая.тн-оор өссөн. Энэ нь Багануурын уурхайн 2015 оны уулын ажлын төлөвлөлтийн хүрээ хязгаараас цааш тооцсон нөөц болно.

Дэд бүтэц: Үйлдвэрийн талбай нь Багануур дүүргээс 4.5км зайтай урд зүгт, уурхайн зүүн хойд талд уурхайгаас 1.4 км зайд байрладаг бөгөөд цахилгаан, дулаан, усан хангамжийн бүх шугамтай бүрэн холбогдсон.

Үйлдвэрлэлийн талбайн хэмжээнд 24 км урттай төмөр зам, "Уул", "Төв", "Галуут" зэрэг цахилгаан хангамжийн гурван дэд станц, тэдгээрээс салбарлан гарсан цахилгаан дамжуулах агаарын шугамууд, УШХ, Уул-2, ТАМАХ оффис, НБАХ-1,2 болон шигших, ангилах байгууламж, ШТС зэрэг дэд бүтцийн гол байгууламжууд үйлдвэрлэлийн талбайд байрлана.


Үйлдвэрлэлийн барилга байгууламжид оффис, ахуй үйлчилгээний газар, хоолны газар, технологийн автомашины засварын хэсэг, үйлчилгээний машинуудын засварын хэсэг, гараж, цахилгаан хангамжийн дэд өртөө, дулаан хангамжийн байгууламжууд, цэвэр бохир усны шугам, сэлбэгийн агуулахууд, гал хамгаалалтын хэсэг, усан сан, компрессорын станцууд болон бусад барилга байгууламжууд байна.

Уурхайн хотхонд 5-9 давхар бүхий барилгууд, нийтийн байр, спорт цогцолбор, хоккейн талбай, Багануур сувилал байрладаг.

Ажиллах хүч: Багануурын нүүрсний уурхай 10 хэсэгтэй, 1123 ажиллагсадтай, үүнээс эрэгтэй 1000, эмэгтэй 139, гэрээт ажилтан 63 ажиллаж байна. Тус уурхайд ажиллагсдын насны ангилалыг авч үзвэл 18-30настай 157; 31-40 настай 485; 41-50 настай 331; 51-60 настай 154; 60-с дээш настай 1 хүн тус тус ажиллаж байна.

Уурхайн хэсгүүдэд ажиллагсдын тоо: Үйлдвэр борлуулалтын алба-29, Худалдаа хангамж хариуцсан хэлтэс 41, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтэс 20, Захиргаа хүний нөөц удирдлагын хэлтэс 14, Технологийн бодлогын хэлтэс 16, техникийн бодлогын хэлтэс 9, Санхүү эдийн засгийн бодлогын хэлтэс 19, Судалгаа хөгжлийн хэлтэс 5, Спорт цогцолбор 10, Ахуй үйлчилгээний тасаг 22, Мэдээлэл технологийн алба – 16, Дотоод хяналт шалгалтын алба-5, Захирал 6 Уулын 1-р хэсэг 89, Нүүрс бутлан ачих хэсэг 145, Технологийн автомашин, механизмын засварын хэсэг 84, Ус шүүрүүлэх хэсэг 16, Уулын 2-р хэсэг 129, Технологийн автомашин ашиглалтын хэсэг 204, Эрчим хүчний нэгдсэн хэсэг 64, Үйлчилгээний автомашины хэсэг 98, Засварын нэгдсэн хэсэг 78.

Уулын ажлын технологийн дэс дараалал



ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин цаг уурын нөхцөл:

Багануурын нүүрсний орд нь Хэнтийн нурууны салбар уулсын мужид багтдаг, далайн түвшнээс дээш 1290-2220 м-т өргөгдсөн, рельефийн ялгаатай орчинд Хэрлэн голын сав газрын өргөн уудам тэгшивтэр, тал хөндийд байрладаг.

Өвөл: Энэ бүс нутагт өвөл 10-р сарын 26-наас дараа жилийн 3-р сарын 19-нийг хүртэл 144 хоног үргэлжилнэ. Өвлийн улиралд нүүрс олборлолт ихэсдэг ба ажилчдын гадаа ажиллах нөхцөл ихээхэн хүндэрч, машин техникийн саатал, эвдрэл нэмэгддэг. Өвлийн улиралд нүүрсний уурхайд газар, зам, нүүрсний өнгөн үе хөлдүү, уурхайн гүнд ус мөстсөн байдаг.

Хавар: Хаврын улиралд нарны илч нэмэгдэж, салхи шуургатай болдог бөгөөд өвлийн төгсгөлөөс зуны эх хүртэл (3-р сарын 19-нөөс 5-р сарын 21 хүртэл) 63 хоног үргэлжилдэг. Салхи шуурганы улмаас ихээхэн хуурайшилттай болж тоос шороо дэгдэнэ.

Зун: Зуны улирал 5-р сарын 21-нээс 9-р сарын 5 хүртэл 107 хоног үргэлжилдэг. Энэ хугацаанд харьцангуй халуун, хур тунадасны дийлэнх хэсэг нь унадаг. Энэ улирал нүүрсний уурхайн үйлдвэрлэлд хамгийн их өгөөж авчирдаг бөгөөд газар гэсэж, уурхайд ажиллах хөдөлмөрийн нөхцөл таатай болж, нүүрс гаргалт буурдаг.

Намар: Намрын улирал зуны төгсгөлөөс өвлийн эх болтол (9-р сарын 5-наас 10-р сарын 26 хүртэл) 51 хоног үргэлжилдэг. Намрын улирлын гол шинж нь хоног хоногоор агаар, хөрсний температур сэрүүсэж, хяруу унаж, хөрсний ба агаарын анхны цочир хүйтрэл тохиолдоно. Нүүрсний уурхайд өвлийн бэлтгэл хангах, техник технологи, хөдөлмөрийн нөхцөлийг өвлийн горимд шилжүүлэх, цаг агаарын нөхцөлөөр өвлийн ажлын төлөвлөгөө хийж ажиллах шаардлага гарна.

Хур тунадас, чийгшлийн нөхцөл: Багануур цаг уурын өртөөний 2008-2017 оны хур тунадасны мэдээгээр энэ бүс нутагт жилдээ 272.1 мм хур тунадас унадаг бөгөөд үүний 92% нь дулааны улиралд (4-10-р сар), 8% нь хүйтний улиралд (11-3-р сар) ордог.

Дулаан улиралд 50 өдөр бороо, хүйтэн улиралд 25-30 өдөр цас орно. Жилд 80 хоногт тогтвортой цасан бүрхүүл тогтож, 0.14-0.20 г/см нягттай 3-5 см зузаан цас ордог. Дулаан улиралд 20-25 өдөр аянга цахилгаан цахих бөгөөд нэгж талбайд 5-6 ниргэлт болдог. Агаарын харьцангуй чийгшил 64.5% байна. Харьцангуй чийгшлийн жилийн явцын хамгийн их утга нь 1, 12-р сард 73-77%, хамгийн бага утга нь 4, 5-р сард 46-49%

Салхи шуурганы нөхцөл: Багануур цаг уурын өртөөний 2008-2017 оны салхины зонхилох чиглэлийн мэдээнээс үзэхэд энэ бүс нутагт хойд зүгийн салхи зонхилдог бөгөөд 41%-ийн давтагдалтай байна.

2008-2017 оны мэдээгээр энэ бүс нутгийн салхины дундаж хурд 2.4 м/с байна. Жилийн турш 20 өдөр хүчтэй салхи тохиолдож, 20-25 өдөр шороон шуурга шуурна. Хаврын улиралд салхины их хурд 20-22 м/с хүрэх нь түгээмэл байдаг.

Хүчтэй салхи нь уурхайн машин механизмын хэвийн ажиллагаанд, нүүрсний ачилт, зам тээвэрт зохисгүй нөлөөлдөг.

Хүн ам, нийгэм, эдийн засаг

Багануурын нүүрсний уурхай 1978 онд олборлолтын ажлаа эхэлсэнээс хойш 2 жилийн дараа буюу 1980 онд Багануур дүүрэг байгуулагдсан.

Багануур дүүрэг нь Хэрлэн голын усны их хагалбар Таван Сувайн нам дор газрын төв хэсэг Нүүрэнтийн хөндийд, далайн түвшинээс дээш 1276-1380 метрт, Улаанбаатар хотоос зүүн тийш 130км зайд байрладаг нийслэлийн алслагдсан дүүрэг юм.

Багануур хотхон нь уурхайн хойд талд 4.5 км зайд 62,2 мянган га нутаг дэвсгэртэй 41,6 мянган га нь ХАА-н, 19,3 мянган га нь хот суурины, 4,71 га нь зам шугам сүлжээний, 14,26 га нь улсын тусгай хэрэгцээний, бусдыг ойн болон усан сан эзэлдэг, цахилгаан, дулаан, усан хангамжийн бүх шугамтай бүрэн холбогджээ.

Засаг захиргааны 5 хороо, 7824 өрхийн 27440 хүн амтай. Хүн амын 36 хувийг 13-36 хүртэлх насны залуучууд эзэлдэг ба эдгээрийн 32 хувь буюу 8801 нь 0-18 насны хүүхдүүд байна. Нийт өрхийн 41,5 хувь буюу 3248 өрх байр орон сууцанд, 25,8 хувь буюу 2021 өрх амины хашаа байшинд, 2545 өрх гэрт амьдарч байна. Гэрт амьдардаг өрхөөс 287 өрх нүүдлийн мал аж ахуй эрхэлж байна.

Төрийн захиргааны 10, төрийн тусгай чиг үүргийн 6, төрийн үйлчилгээний 14, төрийн бус 63 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит ХК 7, хувийн хэвшлийн 354 аж ахуйн нэгжид 8936 иргэн хөдөлмөр эрхэлж байна. Тус дүүрэг нь нүүрсний уурхайг даган хөгжиж, уурхайчдын жижиг тосгоноос дэд бүтэц сайн хөгжсөн хот болсон ба туршлагатай инженер техникийн ажиллах хүчний хувьд хангалттай газар юм.



ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорхи усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээний үр дүн нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийг цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн уулын үйлдвэр, түүний эргэн тойрон дахь бүс нутагт уулын ажлын явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой.

Орчны агаарт үзүүлэх нөлөөлөл

Тоосны бохирдол. Хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүүрс ба хөрсийг ачиж буулгах, тээвэрлэх зэрэг уурхайлалтын үйл ажиллагааны явцад орчны агаарыг тоосоор бохирдуулах ба уурхайлалтад өртөж эвдрсэн талбай болон гадаад, дотоод овоолгын сул шороо нь салхи шуурганд тоос босох эх үүсвэр болно.

Нүүрс болон хөрс тээвэрлэлтийн авто замыг тогтмол усалж, хайргажуулаагүйгээс тоос босч орчныг бохирдуулна. Уурхайд тэсэлгээ хийснээс газар чичрэх, агаарын хэт даралт үүсэх болон агаарт тоос дэгдэх зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ. |

Хорт хийн бохирдол. Уурхайд тэсэлгээ хийх, нүүрсний шаталт явагдах, хүнд даацын машин техник (автосамосваль, бульдозер, экскаватор г.м)-ийн хөдөлгүүрээс гарах утаанд угаарын хий (CO), азотын дутуу исэл (N₂O), хүхэрлэг хий (SO₂), хүхэрт устөрөгч (H₂S) зэрэг хорт хий ялгаран гарна. Эдгээр хийнүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрөл бүрийн хордлого үүсгэнэ.

Газрын гадарга, хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

Газрын эвдрэл. Уулын 1, 2 дугаар хэсгийн малталт явуулсан талбай, уурхайлалтын гадна байгуулсан автын овоолго, нүүрс, хөрс тээвэрлэлтийн зам, ус шүүрүүлэлтийн газрын доорхи ба дээрх инженерийн байгууламжуудын далан суваг, уурхайн хил, хамгаалалтын суваг болон уурхайн барилга байгууламж зэрэг газрын дээрх ба доорхи инженерийн байгууламжуудыг барьж байгуулах, ашиглах явцад газар эвдрэлд орж унаган төрхөө алдана.

Шимт ба шимэрхэг хөрсний хоргодол. Уулын ажил жил бүр уртын дагуу ахилт хийдэг. Шимт ба шимэрхэг хөрсийг 20-50 см хуулж, агуулах байгуулан хадгалах ба шууд хөрсжүүлэх талбайд авч нөхөн сэргээлтэд ашиглах явцад уг хөрсийг дутуу хуулах, хэт зузаанаар хуулж ул шороотой хольж бохирдуулах, шимт хөрсний агуулахыг шаардлага хангахгүйгээр байгуулах, ус бороо салхиар хийсч

хорогдох, эргүүлэн нөхөн сэргээлтэд ашиглах хэмжээ нь багасах зэргээр сөрөг нөлөөлөл бий болно.

Өнгөн хөрсний бохирдолт. Уурхайд бензин дизель түлш түгээх 3 станц, төрөл бүрийн тос хүлээн авч хадгалах, түгээх 2 складтай ба тосолгоо үйлчилгээний ажил эрхэлдэг 5 хэсэг цех ажиллаж байна. Эдгээр нь барилга, байгууламжийн орчимд хаягдсан нефть бүтээгдэхүүнээр эргэн тойрны хөрс шороо бохирдох мөн бороо, цаны усаар угаагдан хөрсний усыг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлаар бохирдох. Уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбогдон ажилчдын хоолны газар, контор, ахуй үйлчилгээний комбинат, үйлдвэрлэлийн цех хэсгүүдээс үйлдвэрийн хог хаягдал гардаг. Үүнийг ерөнхийд нь хуурай ба шингэн, хортой ба хоргүй гэж ангилан үзвэл:

- Хуурай хатуу хог хаягдал: Төрөл бүрийн төмрийн зоргодос, арчих материал, хаягдал хуучин сэлбэг хэрэгсэл, ган канат, барилгын засвараас гарах хог хаягдал, хуучин дугуй, туузан дамжуулагчийн тууз, уурхайн ашиглагдаагүй талбай болон овоолгын орчмын зам талбайд асгарсан нүүрс г.м.
- Шингэн хог хаягдал: Ажилласан тос, цэвэрлэгээнд хэрэглэсэн бензин, түлш, дулааны станцын үнс, цэвэрлэгээний тунгаасан ус, технологийн дамжлагын ба цехүүдийн нойтон цэвэрлэгээний ус г.м.

Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх нөлөөлөл

Ил аргаар нүүрс олборлох технологийн дагуу гүний усанд байгаа нүүрсийг олборлохын тулд цооногийн аргаар урьдчилан шүүрүүлж, усны түвшинг нүүрсний давхаргаас доош оруулах аргаар олборлолт явуулдаг. Үүний дагуу жил бүр дунджаар 5 сая.м³/жил гүний ус шүүрүүлэн зайлуулж байна. Гүний усны түвшин буурснаар уурхайлалтын орчны гадаргын болон хөрсний усны түвшин буурч, хөрсөнд хуурайшилт үүсэх нөлөөтэй.

Ордын баруун урд талд байрлах Багагүн нуур, ашиглалтын талбайн хойноос урагшаа байрлалтай Хуцаагийн гол, баруун хэсэгт Хужиртын гол, мөн цөөнгүй тооны булаг шанд, рашаантай. Багагүн нуур нь нүүрсний уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байдаг бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас нуурын усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Уурхайн шүүрлийн усаар голын гольдрол, нуурыг тэжээж байгаа нь гадаргын усны найрлага, шинж чанар өөрчлөгдөж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Багануурын уурхайн үйл ажиллагааны явцад уурхайн карьер болон овоолгууд, уурхайн дэд бүтцийн объектуудыг барих явцад тухайн орчны ургамлан нөмрөг хөрстэй хамт хуулагдана. Мөн замын тоос, шорооноос ургамлан нөмрөгийн өнгө зүс нь алдагдах, навчинд түлэгдэлт үүсэх, эрт унах эрсдлийг бий болгодог. Ургамлын бүрхүүлд бохирдуулах бодисын хуримтлал бий болсноос түүний бодисын солилцооны хэм алдагдах, эсийн бүтцэд өөрчлөлт орох, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаахрах, улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог байна. Эндээс үзвэл ашиглалт явуулж буй хэсэгт ургамлын ургац, амьдрал бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхлагдаж орсон хэсэгт хог ургамал ялангуяа шарилж ихээр ургаж, хүн амьтны амьсгалд тоосны

харшил үүсэх нөхцөл болж байна. Ургамлын бүрхэвч устаж үгүй болох нөхцөлд олборлолтын ажил дууссаны дараа уг нутгийн бэлчээрийн нөхөн сэргээх асуудал чухлаар тавигдана.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Багануурын уурхайд ашиглалт явуулах нь амьтны аймаг, ялангуяа хөхтний байршил, тархац, тоо толгойд шууд нөлөөлнө. Хүн, машин техникийн хөл хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс орчин тойрны 2-3 км хүртэлх зайд байгаа зарим том хөхтөн дайжиж зайлна. Уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт шууд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага боловч амьтан устах дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг нөлөөнөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Физик нөлөөлөл

Өрөмдлөг тэсэлгээний явцад газрын хэвлийн геологийн тогтоц өөрчлөгдөх, мөн доргилтын нөлөөгөөр газрын хэвлийн чулуулагт ан цав үүснэ. Багануурын нүүрсний ордыг ашиглах төслийн уурхайн олборлолт, ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгсэл, тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанаас дуу шуугиан үүснэ. Мөн тэсэлгээний үед гарах дуу чимээ, доргилт, зэрэг физик, химийн хүчин зүйлсийн нөлөөлөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Уулын машин, тоног төхөөрөмж, Тэсэлгээнээс үүсэх дуу чимээнээс ойр орчмын амьтад үргэж дайжих байдлаар орчны биотолт өөрчлөлт орох ба ялангуяа уурхай орчмын хөхтөн амьтад, шувуудын төрөл зүйл, нягтшил багасна.

Хам сөрөг нөлөөлөл

Уурхайн талбайн орчимд байрлах хайрга, жонш, цемент зуурмагийн үйлдвэрүүд, төвлөрсөн хогийн цэгийг ил задгай шатааснаас болон төмрийн үйлдвэр, дулааны станцын үйл ажиллагаанаас тухайн бүс нутгийн байгаль орчин ялангуяа агаарын чанарт хам сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Багануурын нүүрсний уурхайг ашиглах бүхий л хугацааны туршид Багануур дүүргийн иргэд болон тус уурхайн талбайн ойролцоо нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй малчин иргэдийн амьдралын хэв маяг, эрүүл мэндэд эерэг болон сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл учруулах боловч улс, орон нутгийн төсвийн орлогын ихэнх хувийг бүрдүүлэх, нийгэм соёлын арга хэмжээ, хандив, тусламж, сайн үйлсийн аян, тогтвортой ажлын байр бий болгож иргэдийн амжиргааны эх үүсвэр болгох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зэргээр тухайн нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөөлөл

Түүх, археологийн өв уурхайн хөрс хуулалт, газар шорооны ажилд өртөж болзошгүй.

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилтууд

1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах бодлого төлөвлөлтийн баримт бичиг болох БОМ-ийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулан батлуулах, биелэлтийг хангуулан оршин суугчид болон холбогдох газруудад тайлагнаж ажиллах
2. Байгаль орчны чиглэлээр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актууд, компанийн журам, заавруудыг мөрдлөгө болгох, хуулиар заагдсан зайлшгүй баримт бичгүүдийг хуулийн хугацаанд нь мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гарсан заавар, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах
3. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах ба арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
4. Үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг аргачлал, стандартын дагуу хийх, уурхайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажиллах
5. Дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын арга хэмжээ авах
6. Үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэнд, эд хөрөнгө хүрээлэн буй орчинд үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч ажиллах
7. Хог хаягдлыг ангилах, хадгалах, дахин ашиглаж байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдал дахин боловсруулахад өгч хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зэргээр байгаль орчныг бохирдлоос хамгаалах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, уурхайн үйл ажиллагаа хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгааг бүртгэн судлах, судалгаа шинжилгээний чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах

Хамрах хүрээ

д/д	Хуулиуд	БО-ны багц хуулийн журмууд
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай хууль	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /9.15/
2		Олон нийтийн оролцооны нарийвчилсан журам /18.5/
3		Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал /7.7/
4		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний комиссын ажиллах журам /7.9/
5		Хянан магадлагааны журам /11 зүйл/
6		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлал /9.4/
7	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Ус ашигласны төлбөрөөс хөнгөлөх /20.2/
8		Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ /15.3/
9	Амьтны тухай хууль	Амьтан хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар /4.3.7/
10		Амьтан сэргээн нутагшуулах аргачлал /7.2/
11		Амьтан эзэмшүүлэх журам /13.2/
12	Хог хаягдлын тухай	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тооцох аргачлал /6.1.3/
13		Хог хаягдлын нормативыг тогтоох аргачлал/6.1.4/
14		Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалахтай холбогдсон болон уг үйл ажиллагааг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам /6.1.6/
15		Хог хаягдлын талаарх төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны төлөвлөгөө /7.1.1/
16		Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам /7.1.2/
17		Эх үүсвэрээс гарах хог хаягдлын хор аюулын зэрэглэл тогтоож, кодчилсон жагсаалт /7.1.5/
18		Аюултай хог хаягдлын бүртгэл болон тайлангийн маягтыг батлах /7.1.6/
19		Хог хаягдлын мэдээллийн санг бүрдүүлэх, түүний мэдээллээр бусдад үйлчлэх журам /10.4/
20		Аюултай хог хаягдлын жагсаалт /13.4/
21		Урамшуулал олгох журам /21.2/
22		Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, 2012
23	Усны тухай	Усны нөөцийн зөвлөл, дүрэм, бүрэлдэхүүн /4.6/
24		Усны хэрэглээг тоолууржуулах журам /10.1.3/
25		Сав газрын менежментийн төлөвлөгөөний аргачилсан заавар /10.1.4/
26		Ус бохирдуулах аюултай бодисын жагсаалт /10.1.12/
27		Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийн загвар /24.7/

28		Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам /7.2/
29		Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал /10.1.6/
30		Усны чанарын болон хаягдал усны стандарт /10.1.29/
31		Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүрэг /21.3/
32		Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм /22.4/
33		Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаарх журам /23.3/
34		Бохир ус зайлуулах цэг доторлож ашиглах журам /24.4/
35		Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загвар /28.17/
36	Ус бохирдуулсны төлбөрийн тухай	Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журам /4.5/
37		Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал /5.2/
38		Хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горим /6.2/
39		Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ /7.2/
40		Энэ хуулийн 8.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг заасан журам /8.4/
41		Төлбөрийн тайлангийн маягтын загвар /9.3/

5. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм/нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Уурхайн дотоод тээврийн замуудыг эвдрэл гарсан тухай бүр сэргээн засч тэгшлэх, шаардлагатай замуудыг хайргажуулах, ус зайлуулах далан суваг хийх	Уурхайн дотоод тээврийн зам	м	-	15,000	5,680,380,000.00	3-11-р сар	БОННУ Тайлан 2019он Агаарын тухай хууль
		Уурхайн дотоод тээврийн замын тоосыг дарах усалгааг тогтмол хийх хяналт тавих	Уурхайн дотоод тээврийн зам	км м ³	8,432.8 593.8	35,000 120,000	366,404,000.0	3-11-р сар	Үйл ажиллагааны зардалд
		Машин техникийн хурдны хязгаарт хяналт тавих	Үйлчилгээний машинууд болон автосамосвалууд	-	-	-	ХАБЭАХ Цалингийн зардал	Байнга	БОННУ тайлан 2019 он
		Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг тооцоход ашиглагдах мэдээллийн санг үүсгэх	Хэсэг нэгж	Хүн/өдөр	-	-	Цалингийн зардалд	Жилдээ	БОАудит 2023он
		Карьерт нүүрсний өөрөө шаталтаас үүссэн галыг гарсан даруйд унтраах арга хэмжээ авах	Уулын хэсгүүд	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилдээ	

	Хүнд машин механизмуудын болон бусад тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээг тухай бүр тогтмол хийх	Хүнд машин механизм	-	-	-	ТАМЗХ-ийн зардалд	Жилдээ	MNS 5885:2008	
	Машин механизмуудад найдвартай ханган нийлүүлэгчээс чанарын шаардлага хангасан түлш шатахууныг авч ашиглах	Дизель түлш, АИ80 бензин	-	-	-	Түлш шатахууны зардалд	Байнга	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	
	Тэсэлгээний ажлыг стандартын дагуу өдрийн цагаар гүйцэтгэнэ.								
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Хуцаа голын гольдролд шүүрүүлэлтийн усыг тогтмол цутгах нөхөн сэргээх	Уул-2 хэсэг	м ³	593.8	1400,000	831,320,000.0	жилдээ	БОННУ тайлан 2019 он
		Хужиртын голын гольдролд шүүрүүлэлтийн усыг тогтмол цутгах, нөхөн сэргээх	Уул-2 хэсэг	м ³	593.8	400,000	237,520,000.0	Жилдээ	БОННУ тайлан 2019 он
		Дулааны улиралд дотоод шүүрлийн усыг Уул-1 хэсгийн цөөрөм тэжээх	Уул-1 хэсэг	м ³	593.8	500,000	296,900,000.0	Дулааны улиралд	БОМТ
		Хэрлэн голд цутгах усны хэмжээ	Уул-1 хэсэг	м ³	593.8	1,240,000	736,312,000.0		
		Уурхайн шүүрүүлэлтийн усаар Багагүн нуурыг	Уул-2 хэсэг Багагүн нуур	м ³	593.8	146,600	87,051,080.0	3-10-р саруудад	MNS 4943:2015

	дулааны хугацаанд байнга сэлбэн тэжээх							Хаягдал ус.Ерөнхий шаардлага
	Багагүн нуурын хөлдөлтийн гүнийг давтан тодорхойлох	Багагүн нуур	хүн/өдөр	56,800.0	2	113,600.0 Цалингийн зардал	4-р улиралд	БОМТ
	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга сурталчилгаа хийж, мэдээллийн хуудсуудыг зохих газруудад байрлуулах	Онлайн болон мэдээллийн самбарт	-	-	-	-	Жилдээ	БОАудит 2023он
3	Хөрсөн бүрхэвч Шинээр эвдрэлд орох талбайн үржил шимт хөрсийг хуулах, агуулахад байршуулах	Шинээр эвдрэлд орох талбай	Га м³	3,625.2	30 75000	271,890,000.0	Дулааны улиралд	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
	Шинээр үүссэн шимт хөрсний агуулахыг ургамалжуулах, элэгдлээс хамгаалах	Шинээр үүссэн шимт хөрсний агуулах	хүн/өдөр	56,800.0	12	6,363,200.0 Цалингийн зардал	6-7-р сард	БОМТ
	Цэгүүдэд байрлуулсан бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд цуглуулах, саармагжуулах	ШТС-ууд ШТМ ашигладаг хэсгүүд	хүн/өдөр	56,800.0	8	454,400.0 Цалингийн зардал	Жилд 1 удаа	БОМТ
	2 дахь түүхий эдийн хөрсний бохирдлыг цэвэрлэх, саармагжуулах	2 дахь түүхий эдийн хашаа	хүн/өдөр	56,800.0	14	795,200.0 Цалингийн зардал	Жилд 1 удаа	БОМТ
4	Газрын гадарга, хэвлий Гравитацийн нөлөөллөөр геотехникийн хяналт тавих хүчний явагдах процесст	Ашиглалтын талбайд	-	-	-	Цалингийн зардалд	Жилдээ	БОМТ

	Автозамын сүлжээг оновчтой маршрутаар тогтоож олон салаа зам үүсгэхгүй байхад хяналт тавьж ажиллах	Уурхайн карьерын зам	-	-	-	2,149,000.0	Байнга	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх	
5	Ургамлан нөмрөг	Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлан бүрхэцийг тодорхойлох, эрүүл талбайтай харьцуулах	Эдалбэр талбай	хүн/өдөр	67,900	1	339,500.0	7-р сард	БОМТ
6	Амьтны аймаг	Ан амьтны ажиглалт, тандалтыг хийх	Эдэлбэр талбай	хүн/өдөр	67,900	6	407,400.0	4, 8-р саруудад	Амьтны тухай хууль
		Уурхайн нөлөөллийн бүсэд мал оруулахгүй байх арга хэмжээг авах	Эдэлбэр талбай	-	-	-	-	Жилдээ	
Нийт		Нийт	-	-	-	-	8,478,397,900.0	-	-

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод нөхөн дүүргэлтийг алхагч экскаватороор буюу тээвэргүйгээр 2300.0 мян.м ³ хөрсөөр нөхөн дүүргэлт хийнэ.	м ³	2220000	1,141.5	2,534,130,000.0 Үйл ажиллагааны зардалд	Жилдээ	Уулын ажлын төлөвлөгөө
2.	Биологийн нөхөн сэргээлт	Уулын ажлын онцлогоос хамааран уулын ажлын эцсийн хүрээ хязгаарын дагуу овоолгууд хэлбэржээгүй тул нөхөн сэргээлтийн оронд мод бут тарих, дүйцүүлэн хамгаалах ажлуудыг хийж байна.	-	-	-	-	-	MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
		Үйлдвэрийн талбай дахь мод бутны усалгаа, арчилгааг хийх, тохижилт, байгаль орчны ажлыг хийх	-	-	-	27,909,700.0 Байгаль орчны зардалд	-	
		Үйлдвэрийн талбай орчмыг цэцэгжүүлэх, цэцгийн мандлын үрсэлгээг бэлтгэх	цэцэг /м ² /	210		1,907,000.0 ХА-ны зардалд		
3.	Тэрбум мод	Нэг сая модны стратеги төлөвлөгөөг боловсруулах	га	0.5	-	1,050,000.0 Цалингийн зардалд	4-6-р сард	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
		Хүлэмжинд жимсний болон гоёлын модны үрсэлгээг хийх, усалгаа арчилгааг хийх	м2	350			4-6-р сард	

Мод үржүүлгийн газрын ил талбайд болон хүлэмжинд навчит мод бутны үрсэлгээ хийх, усалгаа арчилгааг хийх	ш	100,000	-	46,760,500.0 Байгаль орчны зардалд	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
Бойжуулгын талбайд мод бутны тарьцыг шилжүүлэн суулгах, арчлах	ш	100,000	-	12,970,000.0 Хөрөнгө оруулалт	
Мод бутыг бортоглох, усалж арчлах	ш	30,000	-	22,737,440.0 Хөрөнгө оруулалт	
Мод үржүүлгийн газрын барилга байгууламжуудыг засаж янзлах				53,807,545.5 Байгаль орчны зардалд	
”Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 15000ш мод бут тарина.	мод /ш/	17000	-	4-10-р сар	
- Багануур дүүрэг Нарийн голын эрэг дагуу	ш	5000			
- Богд уулын нөхөн сэргээлт	ш	5000			
- Ажилчдын амьдрах орчныг сайжруулах	ш	5000			
- Уурхайн бүсийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	ш	2000			
Тарьсан мод бутыг хашиж хамгаалах	га	3,5	-	15,190,454.5 Хөрөнгө оруулалт	
Нийт	Техникийн Биологийн			2,534,130,000.0 182,332,640.0	




“САЯ МОД” төлөвлөгөө

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД “БАГАНУУР” ХК НЭГДЭЖ 2030 ОН ХҮРТЭЛ 1 САЯ МОД ТАРИНА.

Багануур ХК нь 2022-2025 онд жил бүр 10,000 мод бут буюу нийт 40,000 суулгацыг тарихаар төлөвлөсөн. 2026-2030 онд 960,000ш модыг тарих бөгөөд тарьц, суулгацыг мод үржүүлгийн газартаа бойжуулж, тарилтанд шаардлагатай үрсэлгээгээ өөрсдөө хангахаар төлөвлөсөн.

2024 онд “Нэг сая мод”-ны стратеги төлөвлөгөөг боловсруулна.

Нийт тарих модны тоо /ширхэг/




2023 онд барьсан 1 сул хүлэмжинд 50,000ш гоёлын болон жимсний модны үржүүлэг хийнэ. 4 хүлэмжинд тарьсан шилмүүст модны тарьцын усалгаа арчилгааг тогтмол хийнэ.

0,5 га ил талбайд улиас, бургас, шар хуайс, хайлаас модыг мөчрөөр болон үрээр тарилт хийж 50,000ш навчит модны үрсэлгээг хийнэ.

Мөн 100,000 хайлаас модны тарьцыг бойжуулгын талбайд шилжүүлэн усалгаа арчилгааг тогтмол хийнэ. 30,000ш тарьцыг бортоглоно.

Мод үржүүлгийн газрын тарьц бойжуулж байгаа хэсэг болон 10,000 мод тарьсан талбайд хашаа хийж, мал болон туулай зэрэг мэрэгчин амьтдаас хамгаалах ажлыг хийнэ.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Мод тарих, мод үржүүлгийн ажилтай холбоотой 2024 онд шинээр хөрөнгө оруулалтаар шаардагдах техник, тоног төхөөрөмж.

Шаардлагатай тоног төхөөрөмж	Нийт	Зориулалт
Хүлэмж	2ш	Мод бутны тарьц, суулгац бэлдэх
Гүний худаг	2ш	Модны усалгаанд
Ил талбайн мод үржүүлгийн хашаа	3,5 га	Мод үржүүлгийн газарт
Мод усалгааны помп, усны нөөцийн сав	2ш	Мод усалгаа, арчилгаа

БОЛОВСОН ХҮЧИН БА АЖИЛЛАХ ХҮЧ

2022 онд ажиллах хүчийг 2 дахин нэмэгдүүлж үндсэн 4 орон тоотой болсон. Улирлын чанартай 12 ажилтан ажиллуулахаар төлөвлсөн. Үүнд:

Мэргэжил	Орон тоо	Ажиллах хугацаа
Байгаль орчин хариуцсан инженер	1	Үндсэн
Байгаль орчны ажилтан	1	Үндсэн
БО-ы туслах ажилтан	2	Үндсэн
Модны суулгац бойжуулалтанд ажиллах гэрээт ажилтан	4	8 сар
Модны усалгаа арчилгаа хийх гэрээт ажилтан	4	8 сар
Тарилтын үед ажиллах түр гэрээт ажилтан	6	5 сар /хавар 3, намар 2/
Нийт	16	

Уурхайн ажилчдад модны ач тус, мод бут тарих арга, арчилгааны талаарх сургалт, сурталчилгааны ажлыг явуулахаас гадна байгаль орчны ажилчдад онолын болон ижил төстэй мод үржүүлгийн газруудыг үзүүлэх зэрэг практик сургалтыг явуулна.

Мод бутны үрсэлгээ бойжуулах газар байгуулах, тарьц бойжуулах, ойжуулах ажилд мэргэжлийн зөвлөхийг гэрээ байгуулан ажиллана.

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Аварга тосон ОНТХГН-ийг дүйцүүлэн хамгаалах	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв боловсруулах	“Аварга тосон” ОНТХГН	-	-	Цалингийн зардалд	Жилдээ	
		Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх		-	-	15,000,000.0		БОАЖЯ-ны БОНБУ-ийн мэргэжлийн зөвлөлийн санал, БОАЖЯ-ны 06/7270 албан тоот
2.	Гүн галуутай ОНТХГН-т дүйцүүлэн хамгаалах	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв боловсруулах	“Гүн галуутай” ОНТХГН	-	-	15,000,000.0	Жилдээ	БОННУ-ийн нэмэлт тодотголын тайлан
		Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх		-	-			
	Нийт					30,000,000.0		

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Багануур ХК нь өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дүүргийн иргэд, оршин суугчид суурин, нүүлгэн шилжүүлэлт хийх, нөхөн олговор хийхгүй.							
Нийт								

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	2021-2022 онд МУ-ын ШУТИС-ын Хүмүүнлэгийн ухааны салбараар Археологийн судалгааны ажлыг хийлгэсэн. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газар дээр ил ямар нэгэн таних тэмдэггүй булш, хүний үйл ажиллагааны ул мөр, хөрс хуулалтын үед хүн малын яс, ваар сав, хүрэл, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авахыг зөвлөсөн.						
2	Палеонтологийн дурсгал	2013 онд Монгол улсын шинжлэх ухааны академи Палеонтологийн төвтэй гэрээ байгуулан уурхайн ашиглалтын талбайд судалгаа хийлгэсэн. Судалгаагаар цаашид үйл ажиллагаа явуулж байхад явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулах зөвлөмжийг өгсөн.						
Нийт								

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх гэнэтийн аюул осол	Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, анхан тусламжийн сургалтыг зохион байгуулах	Нийт ажлын байр, ажилтнуудад	-	-	ХАБЭА-н зардалд	Жилдээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2	Хөдөлмөрийн аюулгүй бадйлыг хангах, эрүүл ахуйн бодлогыг хэрэгжүүлж ажиллах	ХАБЭА-н ээлжит болон ээлжит бус хяналтыг тогтмол хийх	Нийт ажлын байр, ажилтнуудад	-	-	ХАБЭА-н зардалд	Улирал бүр Тухай бүр	
		ХАБЭА-н сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулах	Нийт ажилчдад	-	-	Сургалтын зардалд	Жилдээ	
		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах		-	-	ХАБЭА-н зардалд		
3	Гал түймрийн аюул	Ажлын байруудад гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдалд хяналт тавих, хангамж бүрдлийг шалгах, Гал эсэргүүцэх дасгал сургуулилтыг зохион байгуулах	Ажлын байрууд, Хэсгүүдийн нийт ажилтнуудад	-	-	ХАБЭА-н зардалд	Жилдээ	Галын аюулгүй байдлын тухай хууль

4	Байгалийн гамшгаас үүдэлтэй аюул осол	Аваар устгах дасгал сургуулилтыг зохион байгуулах	Нийт ажилтнуудад	-	-	ХАБЭА-н зардалд	Улирал бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль
5	Химийн бодисын ашиглалтаас үүсэх эрсдэл	Химийн бодисын эрсдлийн үнэлгээ хийлгэх, болзошгүй ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах	-	-	-	-	2-р улиралд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль БОАудит 2023он
		Химийн бодис болон хийнүүдэд хадгалах зөвшөөрлийг авах	Химийн бодис болон хийнүүд	-	-	-	2-р улирал	
		Химийн бодисын хадгалагдаж химийн тооллогын холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	Дүүргийн МХХ, Цагдаагийн газар	-	-	Үйл ажиллагааны зардалд	2 удаа	
		Химийн бодис ашиглахтай холбогдуулан зохион байгуулах	химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад	-	-	Сургалтын зардалд	Жилдээ	

6	Тэсэлгээ болон тэсрэх материалаас үүдэлтэй аюул осол	Тэсэлгээний хадгалдаг байнгын 24 өндөржүүлсэн байдлын байлгах.	материал агуулахад цагийн бэлэн харуултай	Тэсрэх материал хадгалах агуулах	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилдээ	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль
		Тэсэлгээний журмын дагуу ажлын боловсруулж, мөрдөж ажиллах	ажлыг тэсэлгээний паспорт түүнийг	Уул-1, 2-р хэсэгт тэсэлгээний ажил хийхэд	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилдээ	
Нийт									

11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Дахин ашиглагдахгүй ахуйн хог хаягдлын гурвалсан гэрээг Татварын алба, Багануур тохижилт ОНӨААТҮГ-аар газартай байгуулан төвлөрсөн хогийн цэгт хаяж ажиллах	Оффис, ажлын байруудад	-	102500	12	1,230,000.0	7 хоногт 2 удаа тогтмол	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хог хаягдлыг ангилж хаях, хог ангилалтанд хяналт тавих	Хэсэг нэгжүүд	-	-	-	-	жилдээ	Хог хаягдлын тухай хууль
2.	Үйлдвэрийн	Үйлдвэрийн хог хаягдлыг хэсгүүдээс авч, 2 дахь түүхий эдийн хашаанд ангилж хадгалах	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	-	-	-	-	Жилдээ тогтмол	Хоёрдогч түүхий эдийн нөөцийг зохицуулах журам
		Үйлдвэрийн хог хаягдлаас засвар болон бусад зориулалтаар дахин ашиглах, журмын дагуу борлуулах		-	-	-	-	Тухай бүр	
3.	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилж хадгалах	Аюултай хог хаягдлууд	-	-	-	-	Жилдээ	

	Тос тосолгооны материалаар бохирдсон хөрсийг саармагжуулах	Тос тосолгооны материал ашигладаг ажлын байруудад	-	-	-	-	Дулааны улиралд	Хог хаягдлын тухай хууль
	Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тушаах, устгуулах	Бүх хэсэг нэгж	-	-	-	3,000,000.0	Жилдээ	Хог хаягдлын тухай хууль
	Уурхайн хэсэг нэгжүүдээс гарах хаягдал батерейг цуглуулж тусгайлан хадгалах	Бүх хэсэг нэгж	-	-	-	-	Тогтмол	
4	Цэвэрлэгээ	Гадна талбайн болон дотор орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Хэсэг нэгжүүд гана болон дотор орчин	-	-	-	7 хоног бүр, өдөр бүр	Хог хаягдлын тухай хууль
		Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хийх, холбогдох газарт тайлан, мэдээг хүргүүлэх	Хуваарьт талбай болон хэсэг нэгжүүд	-	-	-	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль
		Хүйтний улиралд цас орсон тухай бүр цэвэрлэн, халтиргаа гулгаанаас сэргийлэх	Бүх хэсэг нэгжүүд	-	-	-	Хүйтний улиралд	
	Нийт					4,230,000.0		

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	
1	Агаар - Бохирдол - Тоосжилт	- Уул-1 хэсэг буюу ТАМАХ-ийн офиссын байр - Уул-2 хэсэг офиссын байр - Захиргаа орчим Дүүрэг гэр хороолол - Дүүргийн төв хэсэг - Нөлөөллийн дээд хэсэг буюу Багануур дүүргийн цаг уурын станцын орчим	Улирал бүр 2 сар тутам	4 удаа 6 удаа	25000	600000 Цалингийн зардалд	MNS 4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага Байгаль орчны баримт бичиг: Агаарын чанарын хяналт, орчны тоосны хэмжилт хийх заавар
2	Гадаргын ус - Хими - Хүнд металл	- Багагүн нуур /баруун/ хэсэг - Багагүн нуур /зүүн/ хэсэг - Хэрлэн голын дээд хэсэг /Нарийний гол цутгаж байгаа хэсгээс дээш 500м зайтай/ - Хэрлэн голын доод хэсэг /Нарийний гол цутгаж байгаа хэсгээс доош 500м зайтай/ - Нарийний гол /Хэрлэн голд цутгахын өмнөх/ - Аягын гол /Хэрлэн голд цутгахын өмнөх/	Дулааны улиралд	4 цэгээс 2 удаа	114000	1368000	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага Байгаль орчны баримт бичиг: Усны дээж авах заавар
3	Багагүн нуур	- Түвшин - Талбай	4-10 сар	2 удаа	Цалингийн зардал		БОННУ-ийн тайлан 2019 он

4	<ul style="list-style-type: none"> Гүний ус - Хими - Хүнд металл - Түвшин 	<ul style="list-style-type: none"> - Ус шүүрүүлэх хэсгийн ус хураагуур - Төмөргүйжүүлэх станцын хажуу дахь ус авах С цэгийн худаг - Дулааны станцаас гарсан устай нийлсэн буюу төв цэвэрлэх байгууламжтай нийлэхээс өмнөх худаг. - Төв цэвэрлэх байгууламжийн бохир устай нийлсэний дараах хаягдал хэсэг - Хужирт голын гольдролд цутгаж байгаа коллектор - Хуцаа голын гольдролд цутгаж байгаа коллектор - Багагүн нуурыг тэжээж байгаа коллектор дээд хэсэг - Багагүн нуурыг тэжээж байгаа тэжээгдлийн нуурт орохын өмнөх доод хэсэг 	Улирал бүр	4 удаа /улирал бүр/	114000	4560000	<p>MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p> <p>MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал ус ерөнхий шаардлага</p> <p>Байгаль орчны баримт бичиг: Усны дээж авах заавар</p>
5	<ul style="list-style-type: none"> Гүний ус - Түвшин 	<ul style="list-style-type: none"> - Гүний усны ажиглалтын цооногуудад 	Сар бүр	12 удаа	Цалингийн зардалд		БОМТ
6	<ul style="list-style-type: none"> Хөрс - Агрохимийн үзүүлэлтүүд 	<ul style="list-style-type: none"> - Тухайн жилийн биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай - Шимт хөрсний овоолгууд №1-№10 - Уурхайн ашиглалтын талбайн урд зах - Багагүн нуурын зүүн тал - Багануур дүүргийн самбарын зүүн тал 	Дулааны улиралд	1 удаа	56900	1140000	Байгаль орчны баримт бичиг: Хөрсний дээж авах заавар

7	Хөрс - Хүнд металлын үзүүлэлтүүд	- Уурхайн захиргаа орчим - Дулааны станц орчим - Шатах тослох материалын агуулахын орчим - ШТС-захиргаа - Хурдас чулуулгийн овоолгын хөрс - Нүүрс буулгаж ачих хэсэг	Дулааны улиралд	1 удаа	43000	860000	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөгдөх дээд хэмжээ Байгаль орчны баримт бичиг: Хөрсний дээж авах заавар
8	- Хөрсөн дэх нефьтийн агууламж	- ШТС уул-1 - ШТС уул-2 - ШТС захиргаа - Бохирдсон хөрс	3, 6, 9-р сар	3 удаа 1 удаа	50000	750000	Байгаль орчны баримт бичиг: Хөрсний дээж авах заавар
9	Цацраг	- Олборлолт явуулж буй нүүрсний мөргөцгүүд - Уурхайн захиргаа - Нөхөн сэргээсэн талбай - Дуулааны станц орчим - Дулааны станцын үнсэн сан - Дүүрэг - Нөлөөллийн дээд хэсэг эрүүл газар	Жилдээ	1 удаа	0000	310000	БОННУ-ийн тайлан 2019он
10	Ургамал	- Уурхайн эдэлбэр талбай - Уурхай орчим - Нөхөн сэргээсэн талбай	Жилдээ	1 удаа	-	-	
11	Амьтан	- Уурхайн эдэлбэр талбай	Жилдээ	1 удаа	-	-	
Нийт						9,588,000	

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах биелэлтийн тайланг гаргаж тайлагнах батлуулах, тайланг гаргаж тайлагнах	4375800 Цалингийн зардал	1-р сар Төлөвлөгөө батлуулах	7-р сар хагас жилийн тайлан	11-р сар бүтэн жилийн тайлан	Байгаль орчны мэргэжилтэн	
2	Байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах хэрэгжүүлж ажиллах	18298800 Цалингийн зардал	1-р сар Төлөвлөх	1-12 сар хэрэгжүүлэх	10-р сар гүйцэтгэл гаргах	Байгаль орчны мэргэжилтэн Бүх хэсэг нэгж, хэлтсүүд	
3	Орчны шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулж шинжлүүлэх, хяналт тавьж ажиллах	2196000 Цалингийн зардал	1-р сар Итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулах	1-10-р сар Хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	12-р сар гэрээ дүгнэж акт үйлдэх	Байгаль орчны мэргэжилтэн, байгаль орчны ажилтан ХХХХ	
4	Байгаль орчны Ерөнхий үнэлгээг хийлгэх	-	1-р сар БОАЖЯ-д хүсэлт хүргүүлэх	2-р сар Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг авах	-	Байгаль орчны мэргэжилтэн	

5	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх	45000000 Байгаль орчны зардал	Тендерийн бичиг баримт бэйлдэх, зарлах	Сонгогдсон зөвлөлтэй гэрээ байгуулан үнэлгээг хийлгэх	БОАЖЯ-аар батлуулах	Байгаль орчны мэргэжилтэн ХХХХ
6	Байгаль орчноо хайрлан хамгаалах, зүй ашиглах, мод бут тарих, арчлах, хог ангилан хаях сургалт	2196000 Цалингийн зардал	Сургалт, сурталчилгааны материал бэлдэх	Сургалтын төлөвлөгөө гаргах	Танхимын хэлбэрээр зохион байгуулах	Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭАХ
Нийт		67,066,600.0				

14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	БОАЖЯамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төсөл хэрэгжүүлэгч дараа оны БОМТөлөвлөгөө , тухайн оны БОМТ-ийн хэрэгжилт, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийн хамт 12-р сарын 31-ийн дотор хүргүүлэх	Цалингийн зардал Бичиг хэргийн зардал Томилолтын зардал	Байгаль орчны мэргэжилтэн	ТехноБХ
2	Нийслэлийн БОГазарт	БОМ-ийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг 3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр албан бичгээр хүргүүлэх	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Тухайн жилийн БОМ-ийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11-р сарын 01-ийн дотор хүргүүлэх БОМТөлөвлөгөөг БОАЖЯамаар батлагдсан гарсан даруй жилийн эхэнд хүргүүлэх	Цалингийн зардал Бичиг хэргийн зардал Томилолтын зардал	Байгаль орчны мэргэжилтэн	ТехноБХ
3	Багануур дүүргийн ЗДТГ “Эрдэнэс МГЛ” ХХК	БОМ-ийн төлөвлөгөө, биелэлтийн	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг	Жилд 2 удаа	Цалингийн зардал Бичиг хэргийн	Байгаль орчны мэргэжилтэн	ТехноБХ

	тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр албан бичгээр хүргүүлэх	оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь		зардал			
4	Дүүргийн оршин суугч, иргэд, байгууллага	Иргэд, ААНБ-уудыг уурхайтай танилцуулах, хорооны оршин суугч, иргэдийн төлөөллийг уурхайн байгаль орчин, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах, илтгэл тавих	Уурхайн товч танилцуулга, байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг иж бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах, хэрэгжилтийн явцыг тайлагнах	Жилд 1 удаа	Цалингийн зардал Бичиг хэргийн зардал Хэвлэл мэдээллийн зардал Зочид төлөөлөгчид хүлээн авах зардал	Байгаль орчны мэргэжилтэн	ТехноБХ

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТОВЧОО

Ажлын нэр		Төсөв /төг/
1	Цэцэрлэгжүүлэлт, тохижилтын ажлын зардал	27,909,700.00
2	10.000 мод тарих ажлын зардал	46,760,500.00
3	Мод үржүүлгийн зардал	53,807,545.50
НИЙТ		128,477,745.5

Барьцаа хөрөнгийн байршуулалт

2024 онд байршуулах барьцаа хөрөнгө /төгрөг/	64,238,872.8
1, 3-р сард байршуулсан	40,000,000.0
4-р сард байршуулах барьцаа хөрөнгө	24,300,000.0
Өмнө жилүүдэд байршуулсан хөрөнгө /төгрөг/	137,460,000.0